

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

АУДИТЫН КОД: ГАГ/2020/02-ГА

Шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээнд
тавих дотоод хяналтыг сайжруулж
ажиллаагүйгээс ТАХ-ний гарах үр дүн
үр нөлөө бага гэж дүгнэхэд хүрч байна.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	5
Хүснэгтийн товъёг.....	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	7-8
БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН	
ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА	9
А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж холбогдох хууль журам аргачлалын дагуу төлөвлөж ажиллажээ.....	9
А.1.1 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2019 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна.....	9
А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээ салбарын бодлого ТЭЗ-д санал үндэслэсэн байна.....	9
А.1.3. Сангийн яам болон ТЭЗ нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэрэгцээ шаардлагын дагуу Сангийн сайдын 295 дугаар тушаалын хавсралтын дагуу 144 төсөл арга хэмжээний ажлуудыг эрэмбэлэн ажиллажээ.....	9-10
А.2.Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан ч зарим ажлын гүйцэтгэл дутуу байна.....	10
А.2.1. Аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжийн зураг төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлсэн ажлын даалгавраар зохиосон боловч зарим нэг захиалагч тал зураг төсвөө хянуулж ажиллаагүйгээс үүдэн зураг төсөвт өөрчлөлт орсон байна.....	10
А.2.2. Барилга байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм, программ өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж албан ёсны зөвшөөрөлтэй программ ашиглаж байна гэж үзэж байна.....	10-11
А.2.3. Төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийн зохистой хэмжээг баримтлан зохиож магадлалаар баталгаажуулан ажилласнаас 5 төсөл арга хэмжээний зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй, зураг төсвийн үнэ нэмэгдэж санхүүжилт нэмж батлуулж байгаа нь зураг төсвийг хянаж магадлалаар баталгаажуулах ажлын хяналт сул гэж дүгнэж байна.....	11
А.2.4.Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг хууль батлуулахаас өмнө боловсруулж баталгаажуулсан ч зарим нэг ТАХ-ний зураг төсөвгүй ажил батлуулсан байна.....	12
А.2.5. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн техникийн нөхцөлийг хуульд батлуулахаас өмнө гаргуулж ажилласан ч зарим нэг барилга байгууламжийн ажил эхэлснээс хойш газрын зөвшөөрөл олгосон, 4 барилга байгууламжийн ажлын газрын зөвшөөрөл олгох тухай захирамж гаргаж ажиллаагүй байна.....	12
А.2.6. Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталж ажилласан боловч ТАХ-ний 26.6 хувийн ажлуудыг намар буюу хүйтний улирал эхлэхээс өмнө захирамж гарган гэрээ байгуулж эхлүүлсэн нь тухайн ажлууд удаашралтай, хугацаандаа ашиглалтад орохгүй эрсдэл үүсэх магадлалтай байна.....	13-14
А.2.7. Хөрөнгө оруулалтын шинж чанартай шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулаагүй байна.....	14

БҮЛЭГ Б. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ БАГА ГЭЖ ДҮГНЭХЭД ХҮРГЭЖ БАЙНА.....14

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.....14

Б.1.1. Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.....14

Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг ханган ажилласан ч зураг төсөв нь хугацаандаа баталгаажиж ирдэггүй, хүлээгддэг, баримт бичгийн бүрдэл дутуу зэрэг шалтгаанаас үүдэн ХАА-ны ажлын үзүүлэлт, явц удааширч хугацаа хойшилсон гэж үзэж байна.....14-15

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу нийт 29 ТАХ-ний ажлуудын баримт бичгийг боловсруулан ажиллажээ.....15

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажиллажээ.....15

Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнажээ.....15-16

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангаж ажилласан ч гүйцэтгэгч гэрээний хугацаа хэтэрсэн, зарим нэг тоног төхөөрөмжийг холбогдох суманд нийлүүлээгүй, эзэмшигч ашиглагчтай гэрээ байгуулж ажиллаагүй байна.....16

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтыг гэрээний дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгээгүй, хугацаа хэтэрсэн, алданги тооцоогүй, алданги тооцсон боловч орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй нийт 8597.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 4275.8 мянган төгрөгийг барагдуулж 4322.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага иргэдтэй гэрээ хийж эзэнжүүлж ажиллаагүй 280250.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичлээ.16-17

Б.2.2. Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгуулахаар гүйцэтгэгчид албан даалгавар өгч ажилласан нь үр дүнд хүрсэн байна.....17-18

Б.2.3. Гүйцэтгэгч төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсныг ажлын гүйцэтгэлийн тайлангаар баталгаажуулан ажилласан байна.....18

Б.3. ТАХ-ний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр дүн бага, ажлын хэсэгт томилогдсон гишүүд ТАХ-нд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....18

Б.3.1. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр ашигтай тогтолцоог бүрдүүлж үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж баталгаажуулжээ.....18

Б.3.2. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь олгосон ч санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүй, зарим нэг ТАХ-ний ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.....18-19

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч үр нөлөө багатай гэж илэрхийлэгдэж байна.....19-20

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшинг хангаж түүний үр дүн, үр ашгийг тооцжээ.....20

Б.4.1. Засгийн газар, ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг тооцож ажилласан байна.....20

Б.4.2. 2019 онд ашиглалтад орсон төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байгаа ч зарим нэг барилга байгууламжийг ажил хүлээлцсэн комиссын актын он сар өдрөөр орлогод аваагүй, ажлын гүйцэтгэл дутуу шалтгаанаар бүртгэл тайланд тусгаагүй байна.....20-22

Б.4.3. Засгийн газар, ТЕЗ-д төсөл арга хэмжээний тухайн жилд батлагдсан санхүүжилтээс 7009.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансанд 92.0 сая төгрөгийг байршуулан ажиллажээ.....22

ДҮГНЭЛТ.....22-23

ЗӨВЛӨМЖ.....23-24

МЭДЭГДЭЛ.....24

Товчилсон үгийн тайлбар

УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд
ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэл
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЭМ	Эрүүл мэнд
ХНХ	Хөдөлмөр нийгмийн хамгаалал
БХБ	Барилга хот байгуулалт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХАХНХ	Хүн ам хөдөлмөр нийгмийн хамгаалал
БХТ	Барилга хөгжлийн төв
ЗТБХБГ	Зам тээвэр барилга хот байгуулалтын газар
ТХОТСХТЖ	Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
БХБ	Барилга хот байгуулалт

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Намар буюу хүйтний улиралд эхэлсэн барилга байгууламж	13-14
Хүснэгт 2	Сонгон шалгаруулалт хийгдсэнээс 2 сарын дараа гэрээ байгуулсан барилга байгууламж	14-15
Хүснэгт 3	Ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламж	20-21

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Тоног төхөөрөмжийн зураг /сүүний хөргөлтийн танк/	17
Зураг 2	Хүлэмж	19
Зураг 3	ХАА-н бүтээгдэхүүн борлуулалтын цэг	19
Зураг 4	Ёнкос, хээлтүүлэгч малын багаж	20
Зураг 5	Ашиглалтад орсон барилга байгууламж	21

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийлээ. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт улсын хэмжээнд нгэдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж иргэд олон нийтэд мэдээлэхэд зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд санхүүжүүлэхээр баталсан 1281 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулна.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, судлаач, шинжээч нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, төрийн захиргааны байгууллага, аймаг нийслэлийн Засаг дарга түүний харьяа байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг болосрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр хүртэл ажлын 34 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ҮАГ-т албан мэйлээр, аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т тус тус хүргүүлэн ажилласан болно.

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх ажлын хоног боломжийн боловч санхүүгийн аудиттай дуусаагүй байсан тул зарим үед ажлын ачаалал их байлаа.

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж холбогдох хууль журам аргачлалын дагуу төлөвлөж ажиллажээ.

А.1.1 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2019 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна.

Булган аймгийн хэмжээнд 2019 онд УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудыг төлөвлөн ажилласан нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тулгуурлан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт уялдуулан Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлүүдийг баримталж аймгийн урт, богино хугацааны бодлого, салбар бүс нутгийн хөгжлийн бодлого, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцон үзэж нэн тэргүүнд шаардлагатай байгаа шинээр барих барилга байгууламж, их засварын ажил, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн жилийн төсөв, нийгэм-эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны болон жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж, нэгдсэн бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөн холбогдох салбаруудаас хүсэлт ирсний дагуу шаардагдаж буй төсөл арга хэмжээний нийт 144 ажлын жагсаалтыг эрэмбэлсэн нь төсвийн тухай хуулийн 27.2.2¹, Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дүгээр тушаалын хавсралт төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 3.1² дэх заалтуудыг тус тус баримтлан ажиллажээ.

Мөн үйл ажиллагааны хөтөлбөр болон 2019 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, аймгийн 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэл сүүлийн 6 жилийн судалгаанд үндэслэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг 59.7 тэрбум төгрөгөөр төлөвлөн боловсруулж төсвийн тухай хуулийн 28.1³ дэх заалтыг баримтлан ажилласан нь төсвийн хязгаарт нийцүүлсэн гэж үзэж байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээ салбарын бодлого ТЕЗ-д санал үндэслэсэн байна.

УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудыг байгууллагуудын ТЕЗ-дийн хүсэлтийг үндэслэн холбогдох дээд шатны яам, сайдуудад 2018 оны 07 сард санал уламжлах тухай хүсэлтийг хүргүүлэн ажилласнаар аймгийн хэмжээнд 7.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээний ажлуудаас өмнөх оны 2 төсөл арга хэмжээний ажлын дутуу санхүүжилтийг хэрэгжүүлэн ажиллахаар батлуулсан байна.

Тухайлбал: Эрчим хүчний сайдад 14, Зам тээврийн хөгжлийн сайдад 14, БСШУС-ын сайдад 43, ХХААХҮ-ийн сайдад 8, Хууль зүй дотоод хэргийн сайдад 5, ЗГХЭГ-ын даргад 5, ХНХ-ын сайдад 6, ЭМ-ийн сайдад 10, БХБ-ын сайдад 15 нийт 120 төсөл арга хэмжээний ажлуудын саналыг хүргүүлэн ажилласнаас дээрх ажлуудын эрх нь аймагт шилжин иржээ.

А.1.3. Сангийн яам болон ТЕЗ нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэрэгцээ шаардлагын дагуу

¹ хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах

² Төсвийн ерөнхийлөн захирагч аймаг нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмуудыг баримтална

³ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хамруулна.

Сангийн сайдын 295 дугаар тушаалын хавсралтын дагуу 144 төсөл арга хэмжээний ажлуудыг эрэмбэлэн ажиллажээ.

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар УТХО-аар хэрэгжүүлэх барилга байгууламжийн, их засварын, тоног төхөөрөмжийн, шугам сүлжээ, авто зам зэрэг төсөл арга хэмжээний ажлуудыг холбогдох агентлаг, байгууллагуудын хүсэлт, зураг төсөв, ТЭЗҮ зэргийг үндэслэн боловсруулж 144 төсөл арга хэмжээний ажлуудыг эрэмбэлэн жагсаалт үйлдэн ажилласан нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалын хавсралт төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журмын 3.6⁴ дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын хавсралт УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журмыг баримтлан ажилласан байна.

А.2. Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан ч зарим ажлын гүйцэтгэл дутуу байна.

А.2.1. Аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилга байгууламжийн зураг төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлсэн ажлын даалгавраар зохиосон боловч зарим нэг захиалагч тал зураг төсвөө хянуулж ажиллаагүйгээс үүдэн зураг төсөвт өөрчлөлт орж байна.

Аймагт УТХО-аар 2019 онд эрх нь шилжиж ирсэн барилга байгууламжийн 5010.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ажлын зураг төсвийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, компанийг сонгон шалгаруулж шалгарсан гүйцэтгэгч компанид зураг төсөв боловсруулах гэрээ байгуулж ажилласны хүрээнд зураг төсөл боловсруулах ажлын даалгавар гарган ажиллаж уг даалгаварт тухайн зураг төслийн ажлын үндсэн үзүүлэлт, тавигдах шаардлага, ажлын даалгаврын утга зэргийг тусгаж өгч ажилласан байна.

Төсөл арга хэмжээний зураг төслийг боловсруулах гүйцэтгэгч компани нь Барилгын тухай хуулийн 12, 14, 19, 24, 25 дугаар зүйл, БХБ-ын сайдын 126 дугаар тушаалаар батлагдсан “барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохицуулах” журмыг мөрдөж, зураг төслийг боловсруулан ажилласан боловч зарим нэг барилга байгууламжийн зураг төсвийг ажлын дунд өөрчлөх асуудлууд гарсан байна.

Энэ нь зураг төсвөө анх гаргахдаа зөвлөж, өрөө тасалгааг оновчтой тусгаж өгөөгүй, мөн ГХБХБ-ийн барилга хот байгуулалтын мэргэжилтнээр хянуулж ажиллаагүйгээс шалтгаалсан гэж үзэж байна.

Тухайлбал: Бугат сумын сургуулийн доторх гал тогоог 3 анги болгон өөрчилж, нэмэлт гэрээгээр хийх 50 хүүхдийн дотуур байр дотор гал тогоог барихаар шийдвэр гарч өөрчилсөн байна.

Мөн Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв нь ГХБХБГ-аар хянагдаагүй, сумын захиргаа өөрсдөө зураг төсвийг баталгаажуулсан боловч тухайн байгууллагын зураг төсөв дутуу хийгдэх эрсдэл үүссэн нь тус цэцэрлэгийн барилгын зургийг 3 бүлгийн анги, эмчийн өрөө, хөгжмийн өрөө гэсэн зургаар хийгдэж гал тогооны зураг тусгагдаагүй орхигдсон, магадлал ороод хянагдаад гарсан гэж байгаа боловч ажлын даалгавар дутуу хийгдэх эрсдэл дагуулж байна.

А.2.2. Барилга байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм, программ өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж албан ёсны зөвшөөрөлтэй программ ашиглаж байна.

Аймагт эрх нь шилжиж ирсэн төсөл арга хэмжээний ажлуудаас 11 барилга байгууламжийн 6768.1 сая төгрөгийн төсөвт өртгийг боловсруулахдаа мэргэшсэн төсөвчнөөр тухайн ажлын төсөвт өртгүүдийг боловсруулан ажиллаж, барилга

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь тухайн захирагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилтэй уялдуулан эрэмбэлсэн байна.

байгууламжийн төсөвт өртгийг албан ёсны зөвшөөрөлтэй, эрхий бүхий байгууллагаас зөвшөөрсөн “Est mator” программ ашиглаж тухайн төсөл арга хэмжээний төсөвт өртгийг ЗТБХБГ-ын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн дагуу төсөвт өртөг, норм, дүрмийг боловсруулж гаргадаг гэсэн тайлбар өгч байна.

Төсөл арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл болон төсөвт өртөг боловсруулж ажиллахад аймгийн ТЕЗ-ийн зүгээс ажлын даалгавар өгч уг даалгавар нь үндсэн үзүүлэлт болон шаардлагын нэр, даалгаврын утга гэсэн 2 чиглэлээр албан даалгаврыг анхааруулах зүйлсийн хамт хүргүүлэн ажиллажээ.

А.2.3. Төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийн зохистой хэмжээг баримтлан зохиож магадлалаар баталгаажуулан ажилласнаас 5 төсөл арга хэмжээний зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй, зураг төсвийн үнэ нэмэгдэж санхүүжилт нэмж батлуулж байгаа нь зураг төсвийг хянаж магадлалаар баталгаажуулах ажлын хяналт сул гэж дүгнэж байна.

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж болон үерийн далангийн нийт 11 төсөл арга хэмжээний ажлуудын зураг төсвийг Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйл, 34.1.4⁵, 34.1.10⁶-д заасны дагуу зураг төсөв хийх гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулж холбогдох зураг төсвийг барилгын хөгжлийн төвөөр хянуулж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулан зураг төсвийн зохистой хэмжээг баримталж, магадлалаар баталгаажуулан ажилласан гэх боловч зарим нэг төсөл арга хэмжээний магадлалын дүгнэлтгүй ажлыг зохион байгуулж, зураг төсөвт өөрчлөлт орж төсвийг нэмэгдүүлэхээр төсөл арга хэмжээний ажил дууссан хойно нь дахин магадлал хийлгэхээр хүргүүлэн ажилласан зөрчлүүд илэрч байна.

Энэ нь зураг төсөвт зарим ажил тусгагдаагүйгээс, мөн өмнөх жилүүдэд магадлалаар баталгаажуулсан зураг төсвөөр ажил эхлүүлснээс болж төсөвт өртөг нэмэгдэж байгаа нь барилга байгууламжийн зураг төсвийн үнийг өнөөгийн үнэ цэнээр тооцоогүй, төсвийг нэмэгдүүлж байгаа нь зураг төсвийг хянаж магадлалаар баталгаажуулах ажлын хяналт сул гэж дүгнэхэд хүргэж байна.

Жишээ: Могод сумын ЗДТГ-ын барилгын зураг төсвийг 2 жилийн өмнө буюу 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр магадлалын ерөнхий дүгнэлт гарч байсан, ажил эхлэхээс өмнө дахин магадлалаар баталгаажуулан ажиллаагүй тул гүйцэтгэгч компаниас барилгын ажил дууссан хойно материал болон замын зардлын өсөлтийн зардал нэмэгдэж санхүүжилт хүрэлцэхгүй өөрсдийн хөрөнгөөр буюу банкнаас зээл авч уг барилгыг ашиглалтад оруулсан гэсэн шалтгаанаар санхүүжилт нэмж хүссэний дагуу зураг төсвийг дахин магадлал хийлгэхээр Барилга хөгжлийн төвд хүргүүлж, 2020 онд аймгийн ОНХС-гаас 50.0 сая төгрөгийг батлуулан магадлалын дүгнэлтийг хүлээж байгаа гэсэн тайлбар өгч байна.

Мөн Сэлэнгэ суманд баригдах хээлтүүлэгч малын тэжээлийн байр барих 28.3, ХАА-н бүтээгдэхүүн борлуулах улсын чанартай хэвтээ тэнхлэгийн авто замын дагуу баригдах 78.0, Бугат сум Түлүүгийн давааны босоо тэнхлэгийн дагуу баригдах ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг байгуулах 198.0, чацарганын талбайд эрчим хүч татах буюу 04 агаарын шугам, 10/04 дэд станц байгуулах 74.6, Бугат сумын Түлүүгийн даваа, Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт баригдах ариун цэврийн байгууламж барих 94.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажлын зураг төсвийг магадлалаар оруулж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн нь барилгын тухай хуулийн 34.1.4, 34.1.10 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид шинээр хэрэгжих барилга байгууламжийн зураг төсвийн үнийг зохиохдоо холбогдох хууль журмын дагуу өнөөгийн үнэ цэнээр, нэмж ажил

⁵ барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах

⁶ барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

хийгдэхгүйгээр төсвийг зохиож батлагдсан төсөвт багтаан, зураг төсвийг магадлалаар баталгаажуулж дүгнэлт гаргуулан ажиллах шаардлагатай байна.

А.2.4. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг хууль батлуулахаас өмнө боловсруулж баталгаажуулсан ч зарим нэг ТАХ-ний зураг төсөвгүй ажил батлуулсан байна.

Аймгийн ХОХБТ-ийн хэлтэс нь УТХО-аар 2019 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлуудын хүсэлтийг зураг төсөв, ТЭЗҮ-ийн хамт хүлээн авч барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжүүдийн нийт 144 ажлуудын жагсаалтыг 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдөр боловсруулан баталгаажуулж төсвийн тухай хуулийн 27.4.4, 28, 29 дүгээр зүйл, барилгын тухай хуулийн 32.1.11⁷ дэх заалт болон Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдлөг болгон ажилласан ч Бугат сумын Түлүүгийн даваа, Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт баригдах ариун цэврийн байгууламж барих 94.8 сая төгрөгийн ажлуудыг 2018 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 17 дугаар хуралдаанд УТХО-аар хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний барилга байгууламжийн жагсаалтад тусгагдаагүй, ИТХ-д танилцуулаагүй, зураг төсөвгүй ажлуудыг батлуулсан зөрчлүүд илэрсэн нь Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан журмын 3.5⁸ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

А.2.5. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн техникийн нөхцөлийг хуульд батлуулахаас өмнө гаргуулж ажилласан ч зарим нэг барилга байгууламжийн ажил эхэлснээс хойш газрын зөвшөөрөл олгосон, 4 барилга байгууламжийн ажлын газрын зөвшөөрөл олгох тухай захирамж гаргаж ажиллаагүй байна.

УТХО-аар 2019 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний ажлуудаас Могод сумын ЗДТГ-ын, Бугат сумын 240 хүүхдийн суудалтай сургуулийн, Хутаг-Өндөр сумын сургуулийн өргөтгөлийн, Бүрэгхангай сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлууд нь тухайн байгууллагын эзэмшлийн газарт баригдаж шинээр Нийгмийн даатгалын сангийн барилгын ажлын газрын зөвшөөрлийг газрын тухай хуулийн 27.1-27.3 дах заалтуудын үндэслэн 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/516 тоот сумын Засаг даргын захирамж гарч газрын зөвшөөрөл олгон ажиллаж, төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон холбогдох баримт материал, техникийн нөхцөлийг ТБОНӨБАҮХА тухай хуулийн 11 дэх заалтын дагуу бүрдүүлэн ажиллаж, ажил тус бүрээр анхан шатны баримтуудыг архивлан үдэж ажиллажээ.

УТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний ажлуудын зарим нэг барилга байгууламжийн ажлын газрын зөвшөөрөл олгох тухай захирамж гараагүй, газрын гэрчилгээ олгох тухай захирамж гарсан ч зарим барилгын ажил эхэлсэн хойно газрын зөвшөөрлийг олгосон зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал:Шинэ хөдөө төслийн 17, 18 дугаар багцад зарлагдсан Булган сум 1-р багт босоо тэнхлэгийн дагуу ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэгийн ажлын газрын зөвшөөрлийг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/314 тоот газар эзэмшүүлэх тухай захирамж гарсан нь уг ажлын гэрээг гүйцэтгэгч компанитай 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хийсэн, ажил эхэлснээс хойш газрын зөвшөөрлийг олгосон, Сэлэнгэ суманд баригдсан хээлтүүлэгчийн малын тэжээлийн байр барих, Бугат сум, Түлүүгийн давааны хэвтээ тэнхлэгийн дагуу ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг барих, Бугат сумын Түлүүгийн даваа, Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт баригдах ариун цэврийн байгууламж барих ажлуудын газрын гэрчилгээ болон зөвшөөрөл олгох захирамж гаргаагүй байна.

⁷ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн санхүүгийн жилд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий төслийн жагсаалтыг тусгайлан гаргаж, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээтэй хамт ирүүлнэ.

Цаашид шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудын газрын зөвшөөрлийг барилга байгууламжийн ажил эхлэхээс өмнө газрын тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлж ажиллаж байх шаардлагатай байна.

А.2.6. Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталж ажилласан боловч ТАХ-ний 26.6 хувийн ажлуудыг намар буюу хүйтний улирал эхлэхээс өмнө захирамж гарган гэрээ байгуулж эхлүүлсэн нь тухайн ажлууд удаашралтай, хугацаандаа ашиглалтад орохгүй эрсдэл үүсэх магадлалтай байна.

УТХО-аар 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний 12 ажлын эрх аймагт шилжиж ирсний дагуу Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан ТХОТСХТ-ын журмын 3.1-д заасан зарчмууд, 3.2⁹, 3.7¹⁰, 4 дэх заалтуудыг мөрдөн ажиллаж ТЕЗ-д төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компанийг сонгосон тухай үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТАХ-ний ажил тус бүр дээр захирамж гарч гүйцэтгэгч компаниудтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажилласан байна.

Аймгийн хэмжээнд ТЕЗ-д эрх шилжин ирсэн 12 ТАХ-г 7009.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр баталснаас шинэ хөдөө төсөл хөтөлбөрийн 2 тэрбум төгрөгийг Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн А/257 тоот захирамжийн хавсралтаар 18 багц ажилд хуваан баталж үнэлгээний хорооны гишүүд томилогдон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулснаас 8 багцад гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, 10 багцын ажлыг шууд гэрээ байгуулан ажиллажээ.

Аймагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажлуудын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажиллах, санхүүжилтийг олгох тухай захирамжийн баталсан он сар өдөр хавсралтыг түүвэрлэн үзэхэд 2019 оны 04-10 саруудад хэрэгжиж эхлэх боломжтойгоор ТАХ-ний ажлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж ажиллахаар санхүүжилтийг батлуулсан нь хугацаандаа хэрэгжих боломжтой гэж үзэж байгаа боловч 10 сард эхэлсэн ТАХ-ний ажлууд хугацаандаа дуусахгүй, хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан дулааны улиралд дуусгахаар гэрээний хугацааг сунган ажиллажээ.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	ТАХ-ний нэр	Захирамжийн он сар өдөр дугаар	Гүйцэтгэгч компанийн нэр	Төсөвт өртөг
1	Бугат сумын Түлүүгийн даваа, Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт баригдах ариун цэврийн байгууламж барих ажил	2019.10.09 А/485	"Суутай өргөө" ХХК	94858.0
2	Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлгийн засвар	2019.10.08 А/482	"Хурмастын хүлэг" ХХК	10000.0
3	Хутаг-Өндөр сумын сургуулийн барилгын өргөтгөл 240 суудал	2019.10.02 А/465	"Алтайн бумбат" ХХК	1125559.2
4	ХАА-н бүтээгдэхүүн борлуулах улсын чанартай хэвтээ тэнхлэгийн авто зам дагуух цэг байгуулах	2019.10.02 А/466	"Өлзий хутгийн наран" ХХК	198000.0
5	ХАА-н бүтээгдэхүүн борлуулах улсын чанартай босоо тэнхлэгийн авто зам дагуух цэг байгуулах			78000.0
6	Сүүний хөргөлтийн танк	2019.10.01 А/464	"Согриглун"	263200.0

⁹ Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-д заасан зарчмыг баримласан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төсвийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна.

¹⁰ ТЕЗ төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэн аймаг орон нутгийн хэрэгцээ болон саналыг салбарын бодлоготой уялдуулан, өгөгдсөн санхүүгийн эх үүсвэр, төсвийн хязгаарт багтаан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төслийг боловсруулан

7	Айраг хадгалах хөргүүрт чингэлэг	2019.10.04 A/472	ХХК	17050.0
8	Арьс нэхий элдэх иж бүрэн төхөөрөмж	2019.10.22 A/519	"Жем руби" ХХК	127500.0
Нийт дүн				1914167.2

Дээрх хүснэгтээс харахад аймагт хэрэгжүүлэх барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг нийт 29 ТАХ-ний ажлуудын 8 буюу 26.6 хувийн ажлын санхүүжилтийг намар буюу 10 сард батлуулж ажилласан нь Сангийн яамнаас эрх шилжиж эрхтэй холбогдуулан үзэж байгаа ч тухайн ажлууд хугацаандаа ашиглалтад орохгүй, удааширч барилгын чанар муу баригдах эрсдэл үүсэх магадлалтай байна.

А.2.7. Хөрөнгө оруулалтын шинж чанартай шинж чанартай бус төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан уу.

Үгүй.

БҮЛЭГ Б. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ БАГА ГЭЖ ДҮГНЭХЭД ХҮРГЭЖ БАЙНА.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.

Б.1.1. Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

УТХО-аар 2019 онд хэрэгжүүлэх 12 төсөл ТАХ-ний ажлуудын эрх холбогдох сайдын багцаас 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд эрх шилжүүлэх тухай тушаалууд аймагт ирсний дагуу хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулж тендерийн бичиг баримт бүрдүүлэн тендер зарлах сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг эхэлсэн байна.

ТАХ-ний сонгон шалгаруулалтын ажлын үнэлгээний хорооны гишүүдийг сонгож тендер зарлаж, гэрээ байгуулах хүртэлх ажилд зарцуулсан хоногийг судалгаагаар гарган үзэхэд тендерийн үйл ажиллагаанд дунджаар нэг тендер шалгаруулах ажиллагааг ажлын 30 хоногт багтаан хийсэн нь боломжийн хугацаанд төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн гэж үзэж байна.

Б.1.2. Төсөл, арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг ханган ажилласан ч зураг төсөв нь хугацаандаа баталгаажиж ирдэггүй, хүлээгддэг, баримт бичгийн бүрдэл дутуу зэрэг шалтгаанаас үүдэн ХАА-ны ажлын үзүүлэлт, явц удааширч хугацаа хойшилсон гэж үзэж байна.

Аймагт хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудын үнэлгээний хороо байгуулах тухай захирамжийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1.1¹¹, 46.1.2¹², 46.1.3¹³, 47.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн үнэлгээний хорооны гишүүдийг ажил тус бүр дээр томилон ажилласан ч зарим нэг төсөл арга хэмжээний тендерийн үйл ажиллагаа нь эрх шилжин ирснээс хойш 4 сараас 6 сарын дараа тендер шалгаруулалт явагдаж гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулснаас хойш 2 сарын дараа гэрээ байгуулан ажиллажээ.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	ТАХ-ний нэрс	Эрх шилжин ирсэн он сар өдөр	Үнэлгээний хороо байгуулсан он сар өдөр	Тендер зарласан он сар өдөр	Гэрээ байгуулсан он сар өдөр
---	--------------	------------------------------	---	-----------------------------	------------------------------

¹¹ энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах

¹² үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж гарсан зөрчлийг арилгуулах

¹³ үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр

1	Нийгмийн даатгалын барилгын ажил	2019.02.14 A/69	2019.06.10 A/315	2019.06.14	2019.08.06 A/404
2	Хутаг-Өндөр сум сургуулийн өргөтгөлийн барилга /240 суудал/	2019.02.14 A/69	2019.07.17 A/376	2019.08.12	2019.10.02 A/465
3	Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	2019.02.14 A/69	2019.03.07 A/124	2019.03.18	2019.05.27 A/290
4	Шинэ хөдөө төсөл	2019.04.12 A/106	2019.05.10 A/267	2019.06.10	2019.08.02 A/399, 2019.09.16 A/449
5	Бугат сумын Түлүүгийн даваа, Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт баригдах ариун цэврийн байгууламж барих ажил	2019.04.04 A/121	2019.08.02 A/397	2019.08.19	2019.10.09 A/495

Дээрх хүснэгтээс харахад ХАА-ны ажил удааширсан хугацаа хойшилсон шалтгаан нь ТАХ-ний зарим нэг ажлын зураг төсөв магадлалаар ороогүй, зураг төсөв нь хугацаандаа баталгаажиж ирдэггүй, бичиг баримтын бүрдэлт хангалтгүйгээс шалтгаалан ажлын үзүүлэлт болон явц удаашрахад хүргэж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Цаашид үнэлгээний хороонд томилогдсон гишүүд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.2, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан журмын 1.2, 1.3 дахь заалтыг баримтлан ажиллаж тендерийг хянан үзэх, үнэлэх, заавар зөвлөгөө өгч ажлыг сайжруулан ажиллах шаардлагатай байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу нийт 29 ТАХ-ний ажлуудын баримт бичгийг боловсруулан ажиллажээ.

УТХО-аар 2019 онд хэрэгжүүлэх 12 төсөл арга хэмжээний эрх аймагт ирсний дагуу шинэ хөдөө төслийн 1 ажил нь 18 багцад хуваагдан нийт 29 төсөл арга хэмжээний ажлуудын тендерийн баримт бичгийг аймгийн ОНӨГ нь ТБОНХБАҮХА тухай хуулийн 19.1¹⁴, 19.2¹⁵-т заасны дагуу тендерийн баримт бичгийг бэлтгэн ажиллаж гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад заавар аргачлалын дагуу бэлтгэн гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, зураг төсөв, санхүүгийн чадавх, тендерийн жишиг маягтууд зэргийг ажлын даалгаварт тусган хэрэгжүүлж төсөл арга хэмжээний ажил тус бүр дээр анхан шатны бүрдүүлэх баримт бичгийг боловсруулж архивын нэгж болгон ажиллажээ.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажиллажээ.

Шинээр 2019 онд УТХО-аар хэрэгжсэн 29 төсөл арга хэмжээний эрх аймагт ирснээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн заалтууд болон Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах" журмын 5.2.2, Сангийн сайдын 330 дугаар тушаалаар баталсан 1, 2, 3 дугаар хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар тендерийн бичиг баримтыг боловсруулан, тендерийн урилгыг Булган аймгийн веб сайт болон засгийн газрын tender.gov.mn веб сайтад тус тус мэдээлж, тендер хүлээн авах эцсийн хугацаанд багтааж саналаа ирүүлсэн тендерт оролцогч аж ахуйн нэгж, компаниудаас хамгийн сайн үнэлэгдсэн нэг

¹⁴ Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

¹⁵ Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

оролцогчийг сонгон шалгаруулж зөвлөмж болон мэдэгдэл хүргүүлэх тухай албан тоотыг ажил тус бүр дээр гаргаж аймгийн ЗД-д хүргүүлэн ажиллажээ.

Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнажээ.

Аймгийн ОНӨГ нь 2019 оны ХАА-ны тайланг Сангийн сайдын 363 дугаар тушаалаар баталсан журамд заасан маягтын дагуу хагас бүтэн жилээр хугацаандаа буюу 2019 оны 07 дугаар сарын 04-ний 110, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 08 тоот албан бичгээр тус тус тайланг хавсарган хүргүүлэн ажиллажээ.

ОНӨГ-ын ХАА-ны тайлагнасан бүтэн жилийн тайлангаас үзэхэд аймагт эрх нь шилжиж ирсэн, шинээр тендер зарлагдсан 7.5 тэрбум төсөвт өртөгтэй 9 ТАХ-ний ажлуудын гэрээний дүнг 5.1 тэрбум төгрөгөөр баталснаар тендер шалгаруулалтыг цахимаар зарлаж төлөвлөгөө, хэрэгжилтийн биелэлтийг 100 хувиар дүгнэн тайлагнаж Сангийн сайдын 363 дугаар журмаар батлагдсан маягт 2-8 дугаар маягтын дагуу тайлагнасан байна.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангаж ажилласан ч гүйцэтгэгч гэрээний хугацаа хэтэрсэн, зарим нэг тоног төхөөрөмжийг холбогдох суманд нийлүүлээгүй, эзэмшигч ашиглагчтай гэрээ байгуулж ажиллаагүй байна.

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтыг гэрээний дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгээгүй, хугацаа хэтэрсэн, алданги тооцоогүй, алданги тооцсон боловч ОНТО-ын дансанд төвлөрүүлээгүй нийт 8597.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 4275.8 мянган төгрөгийг барагдуулж 4322.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага иргэдтэй гэрээ хийж эзэнжүүлж ажиллаагүй 280250.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичиж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар УТХО-аар хэрэгжсэн 7009.9 сая төгрөгийн 29 ТАХ-ний ажлуудаас 10 барилга байгууламжийн, хөдөө аж ахуйн чиглэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх 15, засварын 2, өмнөх оны 2 ажлын дутуу санхүүжилт олгох ажлуудыг гүйцэтгэж ажиллажээ.

Дээрх ТАХ-ний ажлуудын гүйцэтгэгч компаниудтай хийсэн гэрээ, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн комиссын акт болон хурлын тэмдэглэл зэргийг түүвэрлэн үзэхэд гэрээний хугацаандаа барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөөгүй хугацаа хэтэрсэн, өмнөх гэрээний хугацааг дууссан хойно нь гэрээ сунгах тухай хугацааг сунгаж гэрээ хийсэн, алданги тооцоогүй, алданги тооцож ажилласан боловч алданги тооцсон төлбөрийг ОНТО-ийн дансанд төвлөрүүлээгүй, тоног төхөөрөмжийг батлагдсан хуваарьт суманд буулгаагүй зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал: Аймгийн ЗД-ын 2019 оны 10 дугаар сарын 04-ний А/472 тоот захирамжийг үндэслэн “Согриглун” ХХК-тай 17050.0 мянган төгрөгийн айргийн хөргүүрт чингэлэг нийлүүлэх ажлын гэрээг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 27-ний өдөр, 263200.0 мянган төгрөгийн 7 ширхэг сүүний хөргүүрт танк нийлүүлэх ажлын гэрээг мөн өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр нийлүүлэхээр тус тус гэрээ байгуулсан боловч гэрээ байгуулсан хугацаандаа тоног төхөөрөмжүүдийг нийлүүлээгүй, айргийн хөргүүрт чингэлгийг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэн өгснөөр ажил хүлээлцсэн комиссын акт үйлдсэн, одоог хүртэл тоног төхөөрөмжийг нийлүүлж ажиллаагүй, хугацаа хэтэрсэн алдангийг 13 хоногоор тооцон үзэж 110.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, айргийн хөргүүрт чингэлгийг батлагдсан хуваарийн дагуу Сайхан суманд хүлээлгэн өгч эзэнжүүлж ажиллахаар 17050.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус бичлээ.

Тус компани нь сүүний хөргөлтийн танкнуудыг гэрээний хугацаандаа нийлүүлээгүй, 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр гэрээний хугацаа сунгах тухай хүсэлт ирсний дагуу гэрээний хугацааг 10 хоногоор буюу 2019 оны 12 дугаар сарын

13-ны өдөр нийлүүлэхээр гэрээний хугацаа сунгах гэрээг байгуулсан нь өмнө нь байгуулсан гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг сунгаж ажиллаагүй, тус компани нь гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй, өмнөх гэрээний хугацаа дууссан хойно буюу 32 хоногийн дараа нийлүүлсэн тул 4211.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, холбогдох тоног төхөөрөмжийг 7 суманд буулгахдаа хавсралтаар Сайхан суманд гэж батлагдсан байхад Баяннуур суманд буулгасан нь Сангийн сайдын 415 дугаар журмын 4.21¹⁶ дэх заалтыг мөрдөж ажиллаагүй, сумдын ЗДТГ-ын скалданд хадгалуулсан гэх боловч ашиглагч байгууллага иргэдийг сонгож гэрээ байгуулан ажиллаагүй 263200.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус бичлээ.

Сүүний хөргөлтийн танкуудыг сумдад буулгасан зураг:



Баяннуур суманд



Дашинчилэн суманд



Бугат суманд



Орхон суманд



Сэлэнгэ суманд



Уньт багт

Мөн ХАА-н бүтээгдэхүүн борлуулах улсын чанартай хэвтээ, болон босоо тэнхлэгийн авто зам дагуух цэг байгуулах 198000.0, 78000.0 мянган төгрөгийн 2 ажлын гэрээг "Өлзий хутгийн наран" ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, гэрээ сунгах хүсэлтийг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсний дагуу мөн өдөр хугацаа сунгах гэрээ хийж ажилласан нь өмнөх гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээг шинэчилж хийгээгүй, ГТН-ийг баримтлан ажиллаагүй зөрчил илэрсэн тул хэвтээ тэнхлэгийн авто зам дагуух ХАА-н цэг байгуулах ажилд 10 хоногийн 990.0, босоо тэнхлэгийн авто зам дагуух ХАА-н цэг байгуулах ажилд 10 хоногийн 390.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн алданги тус тус тооцож, мөн аймгийн СТСХ нь ТАХ-ний ажлуудаас хугацаа хэтэрсэн 2895.8 мянган төгрөгийн алдангийг гүйцэтгэгч компаниас суутган тооцсон боловч хүү торгуулийн дансанд төвлөрүүлж ажиллаагүй зөрчлүүд илэрсэн тул нийт 4275.8 мянган төгрөгийн төлбөрийн зөрчлийг аудитын явцад бүрэн барагдуулж ажиллалаа.

Б.2.2. Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгуулахаар гүйцэтгэгчид албан даалгавар өгч ажилласан нь үр дүнд хүрсэн байна.

Аймагт хэрэгжүүлсэн 12 төсөл арга хэмжээний нийт 29 ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн гүйцэтгэгчидтэй

¹⁶ Барилга байгууламж их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах санхүүжүүлэхийг хориглоно.

гэрээ байгуулан ажиллаж, уг захирамжид ГХБХБГ-ын даргад хяналт тавих үүрэг өгч БХТ-тэй захиалагчийн хяналтын гэрээ байгуулан ажиллаж төсөл арга хэмжээний ажлуудын барилгын ажлын явцад хяналт тавьж алдаа зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцон ажилласан нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар журмын хяналт хэсгийн 5.1-5.4 дэх заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн төсөл арга хэмжээний ажилд үр дүн өгч ажилласнаар 2019 оны байдлаар 3 барилга байгууламжийн, үерийн далангийн 1, хээлтүүлэгч малын тэжээлийн байр 1, чацарганын талбайн эрчим хүч татах дэд станцын 3, их засварын 2 ажил гээд нийт 10 ажлуудыг ашиглалтад оруулж ашиглагч байгууллагууд бүрэн хэмжээнд ашиглаж байгаа нь үр дүнд хүрсэн гэж үзэж байна.

Б.2.3. Гүйцэтгэгч төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсныг ажлын гүйцэтгэлийн тайлангаар баталгаажуулан ажилласан байна.

Аймагт хэрэгжсэн ТАХ-ний 29 ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ТЭЗ нь гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай захирамж гарсны дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан санхүүжилт олгох хуваарь баталж гүйцэтгэгчийн ажлын явц үр дүнгийн тайлан мэдээг БХТ болон ГХБХБГ-ын мэргэжилтний хяналт хийж актаар баталгаажуулсан, санхүүжилт олгох тухай хүсэлтийн дагуу гүйцэтгэгч компаниудын гэрээ хийсэн холбогдох дансанд нийт 2019 оны байдлаар 6917.9 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлэн ажиллажээ.

Гүйцэтгэгч компаниудын санхүүжилтийг барилга байгууламжид зарцуулж байгааг хөндлөнгийн хяналтаар БХТ, ГХБХБГ-ын барилга хот байгуулалтын мэргэжилтнүүд ажлын хуваарь гарган хяналт шалгалтыг хийж үүрэг даалгавар өгч ажлын явц гүйцэтгэлийг ажил тус бүр дээр ил ба далд ажлын актаар баримтжуулан ажиллаж байгаа нь төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан гэж үзэж байна.

Б.3.Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр дүн бага, ажлын хэсэгт томилогдсон гишүүд ТАХ-нд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй гэж дүгнэхэд хүргэж байна.

Б.3.1.Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр ашигтай тогтолцоог бүрдүүлж үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж баталгаажуулжээ.

Шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажлуудаас барилга байгууламжийн 11 ажлуудын зураг төсөв зохиосон, зохиогчийн хяналт хийх компанитай гэрээ хийж ажилласан байна.

Гүйцэтгэгч компаниуд нь аймгийн ГХБХБГ-ын барилга хот байгуулалтын мэргэжилтэнтэй хамтран тухайн барилга байгууламжийн угсралтын ажил зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд ажил эхлэх үеэс дуусах үе хүртэл гэрээний хугацаандаа хяналтыг хийж ил ба далд ажлын акт үйлдэн хяналт хийсэн мөн зааварчилгаа өгсөн тайланг фото зургаар баримтжуулан баталгаажуулан ажиллажээ.

Б.3.2. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь олгосон ч санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүй, зарим нэг ТАХ-ний ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аймагт хэрэгжсэн нийт 29 төсөл арга хэмжээний ажлуудын батлагдсан төсөв, санхүүжилтийн хуваарь, гэрээ, ажлын гүйцэтгэл, санхүүжилт олголтыг түүвэрлэн үзэхэд санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүй, ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчил илэрч байна.

Тухайлбал: Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын эхний санхүүжилтийг 1.2 хувь буюу 5903.9 мянган төгрөгөөр илүү, ногоон байгууламжийн ажил дутуу хийгдээгүй, Могод сумын ажлын гүйцэтгэл тус тус дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон, ХАА-н бүтээгдэхүүн борлуулах улсын чанартай хэвтээ

тэнхлэгийн авто зам дагуух цэг байгуулах ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүрээгүй байхад 88 хувийн санхүүжилт олгосон байна.

Дээрх зөрчил нь барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГ-т даалгасан боловч тус газар нь ажлын гүйцэтгэлийг үнэн бодитоор гараагаагүй зөрчил илэрч байгаа нь Засаг даргын гүйцэтгэгчид гэрээ байгуулж эрх олгох тухай захирамж, Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан журмын 4.5.7¹⁷ дах заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.



Бугат сум Түлүүгийн давааны хэвтээ тэнхлэгийн авто зам дагуу ХАА-н борлуулалтын цэгийн ажил Цаашид барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг үнэн зөвөөр тайлагнаж санхүүжилтийг хуваарийн дагуу олгож байх шаардлагатай байна.

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч үр нөлөө багатай гэж илэрхийлэгдэж байна.

Аймагт хэрэгжсэн нийт 29 төсөл арга хэмжээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэл, мэдээ, тайлан тайлагнасан байдал зэрэгт ТЕЗ барилгын тухай хуулийн 35.1.3 35.1.4, 37.1.4, 37.1.5 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч зарим нэг ажлын гүйцэтгэлд хяналт тавих нь сул байна.

Тухайлбал: Барилга байгууламжийн газар олголт болон газрын зөвшөөрөлгүй барилга байгууламж баригдсан, холбогдох байгууллага нь төсөл арга хэмжээгээр ажлын тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй, тоног төхөөрөмж болон мал аж ахуйн нийлүүлэлтийн ажилд томилогдсон комиссын гишүүд хяналтыг бүрэн тавьж ажиллаагүй зөрчлүүд илэрч байна.

Иймд шинэ хөдөө төслөөр хэрэгжсэн 54519.4 мянган төгрөгийн зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багажуудын, 334200.0 мянган төгрөгийн үнэтэй 6 ширхэг 22 иж бүрдэлтэй төмс хүнсний ногооны тоног төхөөрөмж зэргийг батлагдсан хуваарьт сумдад буулгасан боловч эзэнжүүлж ашиглагчтай гэрээ байгуулж ажиллаагүй, ХТҮА нь 1178.1 мянган төгрөгийн үнэтэй нийллэг хүлэмжийг орлогод авч өглөгөөр тусгаж тайлагнаагүй, 94 тооны 200300.0 мянган төгрөгийн үнэтэй Герефорд болон сэлэнгэ үүлдрийн бухыг гэрээний дагуу хүлээн авч захирамжийн хавсралтаар баталсан хуваарьт газруудад хүлээлгэн өгөөгүй, дуслын усалгааны системийн 7 иж бүрдэл бүхий 22 тоног төхөөрөмжөөс 5 тн-ний усны ёнкос нийлүүлэхээс тооцоолсон хэмжээнээс нь бага усны ёнкос нийлүүлсэн зөрчилд аймгийн ТЕЗ-д ажил сайжруулах зөрчлийг арилгуулахаар 589019.4 мянган төгрөгийн, ХТҮА-нд 1178.1 мянган төгрөгийн албан шаардлага тус тус бичлээ.

¹⁷ Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл /энэ журмын дөрөв, тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргана.



Хүлэмж



Гадна гялгар уут



Усны ёнкос



Зохиомол хээлтүүлэгчийн багаж

ТЕЗ нь өөрийн багцад батлагдсан барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийн мэдээ тайлан, ажлын явц, үр дүнгийн болон ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээ тайланг Сангийн сайдын 415 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу мэдээлэхээс тус журмын 6.2 дахь заалтын дагуу сар бүр санхүүжилт, ажлын явц гүйцэтгэлийн мэдээг мэдээлэн ажиллаж, 6.4.¹⁸ дэх заалтад тусгагдсаны дагуу ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээ тайланг 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 01/439 тоот албан бичгээр хавсралт маягтаар хугацаанд нь мэдээлж ажиллажээ.

Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшинг хангаж түүний үр дүн, үр ашгийг тооцжээ.

Б.4.1. Засгийн газар, ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг тооцон ажилласан байна.

Аймагт шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлуудын төлөвлөгөөг боловсруулахдаа ажил тус бүр дээр хүрэх түвшин үр дүнг тооцон гаргаж ажилласны дагуу УТХО-аар 2019 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажлуудыг аймгийн нийгэм эдийн засаг болон хөгжлийн бодлогод тулгуурлаж төлөвлөн батлуулснаар шинээр барилга байгууламж, их засварын ажлуудын бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэн цогцлуулснаар аймгийн гадаад, дотоод үзэмж нэмэгдэж, иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагыг ханган ажилласнаар тухайн жилийн зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлэн ажиллажээ.

Мөн энэ онд ашиглалтад орсон 10 барилга байгууламжуудыг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байгаа нь сургууль цэцэрлэгийн багш, ажилчдын ажиллах, хүүхдүүдийн сурч боловсрох орчин нэмэгдэж хүүхэд тав тухтай, эрүүл аюулгүй

¹⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч нь ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг дараа оны 04 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын наймдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж Сангийн яаманд хүргүүлнэ.

орчинд сургуулийн өмнөх боловсролыг хүртэх, байгууллагын ажилчид эрүүл аюулгүй орчинд ажиллаж, тухайн сумдын иргэдийн төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж байгаа нь тооцоолсон хүрэх түвшин үр дүнд хүрснийг илэрхийлж байна.

Б.4.2. 2019 онд ашиглалтад орсон төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байгаа ч зарим нэг барилга байгууламжийг ажил хүлээлцсэн комиссын актын он сар өдрөөр орлогод аваагүй, ажлын гүйцэтгэл дутуу шалтгаанаар бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажлуудаас Могод сумын ЗДТГ-ын, Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн, Бугат сумын сургуулийн барилга, Сэлэнгэ сумын малын тэжээлийн байр, Үерийн хамгаалалтын суваг, явган хүний замын ажил, Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлгийн засвар, хүний хөгжил төвийн барилгын засвар, чацарганын талбайд эрчим хүч татах 04/10 кв-ын дэд станцын 3 ажил буюу нийт 10 ажилд 3182.7 сая төгрөгийг зарцуулж ашиглалтад оруулсан байна.

Эдгээр барилга байгууламжийн ажлыг хүлээлцсэн комиссын акт, хурлын тэмдэглэл, санхүүжилт олголт, бүртгэл зэргийг түүвэрлэн шалгахад ажил хүлээлцсэн комиссын актад ашиглагч, өмчлөгч байгууллагыг тодорхойлсон байхад холбогдох байгууллага нь санхүүгийн тайлан бүртгэлд орлогод аваагүй, тухайн байгууллагын зураг төсөв болон бусад баримт материалыг архивд хүлээлгэн өгч ажиллаагүй, ажлын гүйцэтгэл дутуу шалтгаанаас тайлан бүртгэлдээ тусгаагүй гэх зэрэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал: Дээр дурдсан 10 төсөл арга хэмжээний ажлуудаас орлогод авч бүртгээгүй Сэлэнгэ сумын хээлтүүлэгчийн малын тэжээлийн байр, Могод сумын ЗДТГ-ын, Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг ажил хүлээлцсэн комиссын актын он сар өдрөөр орлогод авч бүртгээгүй, дараа онд нь бүртгэсэн, ажлын гүйцэтгэл дутуу шалтгаанаар бүртгээгүй гэсэн тайлбар өгч байна.

Ажлын гүйцэтгэл дутууг хүснэгтээр харуулбал:

мян/төг

№	ТАХ-ний нэр	Дутуу ажлуудын утга	Мөнгөн дүн	Тайлбар
1	Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил	Ногоон байгууламжийн зүлэгжүүлэлт /960.9 м2/	20206.4	Хийгдээгүй дутуу ажил
2		Ногоон байгууламж модны суулгац /13м2/	1259.8	Хийгдээгүй дутуу ажил
3	Могод сумын ЗДТГ-ын барилгын ажил	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу замд стандартын дагуу бариул хийж суурилуулах	3178.5	Хийгдээгүй дутуу ажил
4		Галын төмөр шат угсрах		
5		Бохир усны цооногийн гадна талыг эко хавтангаар хучих		
Нийт дүн			25247.7	

Дээрх хүснэгтээс харахад Могод сумын ЗДТГ-ын барилгын ажлын 3178.5, Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн ажлын 21466.2 мянган төгрөгийн дутуу хийгдээгүй үлдсэн ажлуудыг хийлгэхээр ГХБХБГ-т нийт 25247.7 мянган төгрөгийн албан шаардлага бичлээ.



Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөл



Могод сумын ЗДТГ-ын барилга

Мөн Сэлэнгэ суманд баригдсан 28322.0 мянган төгрөгийн үнэтэй малын тэжээлийн байрыг тус сумын ЗДТГ-т 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр комисс ажиллаж ажил хүлээлцэх актыг үйлдэн хүлээлгэн өгсөн боловч орлогод авч бүртгэл тайланд тусгаагүй, ажил хүлээлцсэн комиссын №25/2019 тоот дүгнэлтийн 3.2 дахь хэсгийн а “барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх” гэсэн заалтыг бүрэн баримталж ажиллаагүй, архивд баримт материалыг хүлээлгэн өгөөгүй зөрчил илэрсэн тул Сэлэнгэ сумын ЗДТГ-т тус байрыг орлогод авч бүртгэл тайланд тусгуулахаар албан шаардлага бичиж, ГХБХБГ-т зураг төсөв, баримт бичгийг архивд хүлээлгэн өгүүлэхээр зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Дуусаагүй орхигдсон барилгын хувьд Тэшиг сумын 240 хүүхдийн сургуулийн 950.0 сая төгрөгийн өртөгтэй барилгыг Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК гүйцэтгэгчээр шалгарч ажлын гүйцэтгэлийг 2011 оны 10 дугаар сарын 17-ны 17/2011 тоот гэрээгээр 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр ашиглалтанд оруулахаар гарээнд тусгасан, ямар ажлыг гүйцэтгэж хэдий хэмжээний санхүүжилт авсан нь тодорхойгүй, яамнаас 2011 онд 250.0, 2012 онд 300.0 сая төгрөгийг дуусаагүй барилгын дансанд бүртгүүлсэн, 2013, 2014 онд хэдэн төгрөгийн санхүүжилт авсан нь тодорхойгүй, ажлын гүйцэтгэл 2014 онд ГХБХБГ-ын дүгнэлтээр 45 хувьтай, 2016 онд 78 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч ажиллаагүй, мөн 2017, 2018, 2019 онд огт ажил хийгдээгүй, 2018 онд 200.0 сая төгрөг тусгуулсан ч ажил хийгдээгүй, 2020 оны УТХО-ын төсөвт тус барилгын ажлыг хийлгэхээр төсөв батлуулсан гэх боловч тодорхойгүй байна.

Б.4.3. Засгийн газар, ТЕЗ-д төсөл арга хэмжээний тухайн жилд батлагдсан санхүүжилтээс 7009.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансанд 92.0 сая төгрөгийг байршуулан ажиллажээ.

ТЕЗ нь 2019 онд аймагт эрх шилжин ирсэн 10550.2 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээний ажлуудын тендер болон ХАА-г ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулснаар нийт 29 төсөл арга хэмжээ тус бүр дээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, эрх олгох тухай захирамж гарган төсөл арга хэмжээний санхүүжилтийг төсвийн тухай хуулийн 24.4, 41.2.6 дахь заалтыг баримтлан нийт 7009.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр санхүүжилтийг баталж гэрээ байгуулан ажиллажээ.

Гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулсан 7009.9 сая төгрөгөөс 6917.9 сая төгрөгийг төсөл арга хэмжээний ажилд зарцуулж зайлшгүй шаардлагатай төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 9.2 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430 дугаар тогтоолыг үндэслэн ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулан ажилласан байна.

Аудитаар нийт 932.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын явцад 4.3 сая төгрөгийн төлбөрийн зөрчлийг барагдуулж 4.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 923.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

УТХО-аар хэрэгжсэн “шинэ хөдөө” төслийн төсөл арга хэмжээний ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй комиссын гишүүд, барилга байгууламжийн ажлын явц гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гаргаагүй, санхүүжилтийг бүрэн олгохоор анхан шатны баримт бүрдүүлсэн, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон холбогдох ажилтнуудад арга хэмжээ авах санал хүргүүлж байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Аймагт хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлт, тогтолцоо нь нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулж төлөвлөсөн байна.
- УТХО-аар хэрэгжүүлсэн 5 төсөл арга хэмжээний зураг төсвийг магадлалын дүгнэлт гарган баталгаажуулж ажиллаагүй, барилгын тухай хуулийн 32.1.11¹⁹ дэх заалтыг зөрчиж зураг төсөвгүй 4 төсөл арга хэмжээний ажлуудыг батлуулсан.
- Барилга байгууламжийн ажил эхэлснээс хойш газрын зөвшөөрлийг олгож, 4 барилга байгууламжийн ажлын газрын зөвшөөрөл олгох тухай захирамж гаргаж ажиллаагүй.
- УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээний 26.6 хувийн ажлуудыг намар буюу хүйтний улирал эхлэхээс өмнө захирамж гарган гэрээ байгуулж эхлүүлсэн нь тухайн ажлууд удаашралтай, хугацаандаа ашиглалтад орохгүй эрсдэл үүсэж байна.
- ХАА нь хууль, журмын дагуу зохион байгуулагдсан ч зураг төсөв нь хугацаандаа баталгаажиж ирдэггүй, хүлээгддэг, баримт бичгийн бүрдэл дутуу зэрэг шалтгаанаас үүдэн ХАА-ны ажлын үзүүлэлт, явц удааширч хугацаа хойшилсон үзүүлэлтэй байна.
- УТХО-аар хэрэгжсэн зарим нэг барилга байгууламжийн санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаас ОНХС-гаас 2020 онд 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлуулсан.
- Гүйцэтгэгч компаниуд ТАХ-ний ажлыг гэрээний дагуу хугацаанд нь гүйцэтгээгүй, хугацаа хэтэрсэн, алданги тооцоогүй, алданги тооцсон боловч ОНТО-ын дансанд төвлөрүүлээгүй, зарим нэг тоног төхөөрөмжийг холбогдох суманд нийлүүлээгүй, эзэмшигч ашиглагчтай гэрээ байгуулж ажиллаагүй, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилтийг бүрэн олгосон,
- Шинэ хөдөө төслөөр хэрэгжсэн айргийн хөргүүрт чингэлгийг Сайхан суманд буулгаж хүлээн авснаар акт үйлдсэн.
- УТХО-аар баригдсан 2 барилга байгууламжийг ашиглагч байгууллагууд бүртгэл тайланд тусгаагүй.
- УТХО-аар хэрэгжиж ашиглалтад орсон 2 барилгын ажлын гүйцэтгэл дутуу, дулааны улиралд хийж дуусгахаар албан даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан, барилга байгууламжийн баримт бичгийг архивд өгч ажиллаагүй.
- Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон барьцаа хөрөнгийн дансанд 92.0 сая төгрөгийг байршуулан ажиллажээ.

¹⁹ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

- 2019 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажлууд нь төлөвлөж тооцсон хүрэх түвшин, үр дүнгээ өгч байгаа боловч зарим төсөл арга хэмжээний ажлуудад тавих дотоод хяналт сул, үр дүн бага байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:
Нэг: Аймгийн Засаг дарга З.Батзориг, ХОХБТХ-ийн дарга Д.Буманбаяр, СТСХ-ийн дарга Д.Батцогт нарт

1. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлуудыг төлөвлөж батлуулахдаа зураг төсөвтэй, зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан барилга байгууламжийн ажлыг батлуулж байх.
 2. Барилга байгууламжийн ажил эхлэхээс өмнө газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан газрын тухай хуулийн дагуу барилга байгууламж барих газрын зөвшөөрлийг гаргуулж хянах.
 3. Гүйцэтгэгч компанитай нэмэлт ажлын гэрээ болон гэрээний хугацааг сунгах гэрээ байгуулахдаа өмнөх гэрээний хугацаа хүчингүй болохоос өмнө гэрээг байгуулж ажиллах.
 4. Төсөл арга хэмжээний ажлуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, ажлын хэсэг болон комиссын гишүүдийн хяналтыг сайжруулах тал дээр арга хэмжээ авч ажиллах.
 5. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож байх.
- Хоёр. Аймгийн ГХБХБГ-ын дарга Ү.Бямбасүрэнд
1. Барилга байгууламжийн ажлын явц, гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв, бодит гүйцэтгэлд тулгуурлан гаргаж албан тоотыг хүргүүлж ажиллах.
 2. Ашиглалтад орсон барилга байгууламжийн ажлын баримт бичгийг ажил хүлээлцсэн комиссын актад тусгагдсан хугацаанд архивд хүлээлгэн өгч байх.
- Гурав. Аймгийн ОНӨГ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анхбаярт
1. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан зураг төсөвтэй ажилд тендер зарлаж байх.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

П.МӨНХТУЯА
Б.ЭНХТӨР



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/10

Булган

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторов 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдэв, 2020 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээ төлөвлөгөөний дагуу "Улсын төсвийн 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, ГХБХБГ, ОНӨГ-ын дарга нарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-д даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор /П.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

006010018

D: /bnchig hereg/2020/tushaal/TAatushaal.doc



УТХО-ЫН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨНД
ХИЙСЭН ГҮЙЦЭТЭЛИЙН АУДИТЫН ТӨЛБӨР ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

2020.04.20

Д/д	Албан тушаал	Хариуцах эзэн	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөр зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчлийн нийт дүн	Үүнээс			Булган
						Акт	Албан шаардлага	Баригдуулсан Төлбөр	
1	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, төсвийн мэргэжилтэн	З.Батзориг, Д.Батцогт, Б.Очирсүрэн	ГАГ/2020/02-ГА	Алдани тооцсон мөнгөн дүнг ОНТО-ын дансанд төвлөрүүлсгүй. /Хутаг-Өндөр сумын 240 хүүхдийн сургуулийн барилга ТХЗ/	1391871			1391871	
2	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, төсвийн мэргэжилтэн	З.Батзориг, Д.Батцогт, Б.Очирсүрэн	ГАГ/2020/02-ГА	Алдани тооцсон мөнгөн дүнг ОНТО-ын дансанд төвлөрүүлсгүй. /Төмс хүнсний ногоо т/т Тэнгэр цэцэрлээ ХХК /	1503900			1503900	
3	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, төсвийн мэргэжилтэн	З.Батзориг, Д.Батцогт, Б.Очирсүрэн	ГАГ/2020/02-ГА	Булган сум 1-р баг босоо тэнхлэгийн дагуу борлуулалтын цэг барих ажлын гүйцэтгэгч "Өлзий хутаг наран" ХХК нь хугацаа сунгах гэрээ хийсэн боловч өмнөх гэрээний хугацаа дууссан хойно гэрээг шинэчлэн хийсэн. /10 хоног/	390000			390000	
4	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, төсвийн мэргэжилтэн	З.Батзориг, Д.Батцогт, Б.Очирсүрэн	ГАГ/2020/02-ГА	Түлүүгийн давааны хэвтээ тэнхлэг дагуу борлуулалтын цэг барих ажлын гүйцэтгэгч "Өлзий хутаг наран" ХХК нь хугацаа сунгах гэрээ хийсэн боловч өмнөх гэрээний хугацаа дууссан хойно гэрээг шинэчлэн хийсэн. /10 хоног/	990000			990000	
5	Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, төсвийн мэргэжилтэн	З.Батзориг, Д.Батцогт, Б.Очирсүрэн	ГАГ/2020/02-ГА/01/115	"Соргилун" ХХК-иас УТХО-аар хэрэгжсэн сүүний хөрвүүрт танийг гэрээний хугацаанд нийлүүлсгүй 32 хонгийн 4211100, айргийн хөрвүүрт чингэлтийг 13 хонгийн 110825 төгрөгийн алданийг тус тус тооцож ажлаагүй, айргийн хөрвүүрт чингэлтийг одоо хүртэл холбогдох суманд нийлүүлсгүй.	4321925	4321925			
6	Сэлэнгэ сумын ЗДТ-ын дарга, нягтлан бодогч	Ц.Ууганбаяр, Энхбат	ГАГ/2020/02-ГА/01/89	Сэлэнгэ суманд баригдсан малын тэмээний байрыг орлогоод аваагүй.	28321993		28321993		
7	ХТҮА-ны дарга, нягтлан бодогч	Н.Баасанжаргал, Л.Тунгалаг	ГАГ/2020/02-ГА/02/90	Хүлэмж орлогоодавч, өглөгөөр тайлагнаагүй.	1178100		1178100		

8	Аймгийн Засаг дарга,	З.Батзориг,	ГАГ/2020/02-ГА/03/91	УТХО-аар баригдсан Бүрэгхангай сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ногоон байгууламжийн 21466230 төгрөгийн 2. Могод сумын ЗДТГ-ын барилгын 3178497 төгрөгийн 3 ажлыг тус тус дутуу хийсэн.	24644727	24644727		
9	Аймгийн Засаг дарга,	З.Батзориг,	ГАГ/2020/02-ГА/04/92	УТХО-аар хэрэгжсэн "шинэ хөдөө" төслийн тоног төхөөрөмж болон мал аж ахуйн нийлүүлэлтийн ажлыг хугацаанд нь нийлүүлэггүй, гэрээ хугацаа хэтэрсэн, ашиглагч эзэмшигчтэй гэрээ хийж ажиллаагүй, ажлын гүйцэтгэл дутуу хийсэн.	869269400	869269400		
Нийт дүн				932011916	4321925	923414220	4275771	0

ТӨЛБӨР ЗӨРЧЛИЙН ЖАТГААЛТ ГАРГАСАН:
АХЛАХ АУДИТОР  П.МӨНХТУЯА

Аудитын нэр:

Төсвийн өрөнхийтэм захирагч нар

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө

Аудитын код:

ГАГ/2020/02-ГА

28

10	1	УТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний асуудлын гүйцэтгэлд хяналт сул, барилга байгууламжийн ахын өвч гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гаргасгүй, санхүүжилтийг бүрэн олгоходоор ахын шатны баримт бүрдүүлсэн, барилга байгууламжийн ахын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгоосон. /Албан тоотойр хүргүүлэх/	Самууны шийдэл хэрэгжүүлэх	2020.04.20	Айвгийн Засаг дарга, З.Батзориг,	З.Батзориг,
11	5	Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлуулахдаа зургийг төсвийн ажил батлуулсан, зураг төсвийг магадлан дүнэлтээр батлаахуулаагүй, барилга байгууламж барих ахын газрын нөхцөл байдлыг огдох тулай зориулах гаргалуу, санхүүжилтийг батлагдсан хуваарийг дэлгүүр олгоогүй.	Зөвлөмж өгөх	2020.04.20	Айвгийн Засаг дарга, З.Батзориг,	З.Батзориг,
12	2	Барилга байгууламжийн ахын өвч гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв, бодит гүйцэтгэлд үндэслэн албан тоотойр хүргүүлээгүй, ашиглалт, орсон барилга байгууламжийн баримт бичгийг ариуд хууцаанд нь хүргээгүй.	Зөвлөмж өгөх	2020.04.20	ГХХБ-ын дарга	У.Бямбаагийн
13	1	Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа магадлан дүнэлтээр батлаахуулаагүй зургийг төсвийн ажилд тусгай зориулалттай ажилласан.	Зөвлөмж өгөх	2020.04.20	ОНБГ-ын даргын үүргийг түр орлогч гүйцэтгэгч	Б.Амбанар
Нийт дүн			932,011,916.0			

Бэлтгэсэн: П.Мөнхтуяа
 Ахлах аудитор: Ж.Энхтүвшин
 Хянасан: Д.Амбанар
 Аудитын менежер: Д.Амбанар
 Дарга, тэргүүлэх аудитор:



**БУЛГАН АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас : 7034-2409, Факс: 7034-2409

2020.04.20 № 01/421
танай _____ -ны № _____ -т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Булган аймгийн Могодын сумын ЗДТГ-ын конторын барилга, Бүрэгхангай сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажилд Булган аймаг дахь Төрийн Аудитын 2020 оны 04-р сарын 20-ны өдрийн ГАГ-2020/02/ГА/03/91 тоот албан шаардлагыг ирүүлжээ. Уг албан шаардлагад хариу тайлбар өгөх нь:

1. Могод сумын ЗДТГ-ын конторын барилга угсралтын ажил 2019 оны 05-р сарын 20-нд эхэлж, 2019 оны 12-р сарын 09-нд комисс ажиллуулах тухай албан хүсэлтийн дагуу 2019 оны 12-р сарын 16-ны өдөр улсын комисс ажиллаж дараах үүрэг даалгавартайгаар ашиглалтад оруулсан.
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу замд бариул хийх
 - Дээвэрт гарах галын шат хийх /комиссоос нэмэлтээр үүрэг болгосон/
 - Бохир усны цооногийн шороон хучлагыг эко хавтангаар манах /комиссоос нэмэлтээр үүрэг болгосон/
2. Бүрэгхангай сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил 2019 оны 06-р сарын 12-нд эхэлж, 2019 оны 08-р сарын 12-нд дуусгаж ашиглалтад өгөх байсан боловч ашиглагч, гүйцэтгэгч, зураг төслийн байгууллагын хүсэлтийн дагуу БСШУС-ын яаманд 2019 оны 09-р сарын 25-нд уг асуудлыг танилцуулж, шийдвэрлүүлсэн ба нэмэлт ажлыг гүйцэтгэхдээ магадлалаар баталгаажсан зураг төсвийн дагуу хөрөнгийг шийдвэрлэхээр болсон.

Уг ажлын хүрээнд зураг төслийн байгууллагад хандаж гадна дулаалга, тохижилтын ажлын зураг төслийг захиалж, 2019 оны 12-р сарын 06-ны өдрийн 2109/2019 дугаар магадлалаар баталгаажин хүлээлгэн өгсөн. Тухайн үед ногоон байгууламжийн ажил хийх боломжгүй байсан тул 2020 оны дулааны улиралд багтаан хийлгүүлэхээр тогтсон болно.

Дээрх хоёр барилгад хийгдээгүй ажлуудын шалтгаан нь өвлийн цагт нойтон ажилбар хийгдөхтэй холбогдуулан чанар, асуулгүй байдал сөргөөр нөлөөлөх байсан тул захиалагчийн зүгээс холбогдох шийдвэрийг гаргасан бөгөөд Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6 дахь заалтын дагуу комиссоос өгсөн үүрэг даалгаврыг 2020 оны 06-р сарын 15-ны дотор гүйцэтгүүлэхээр холбогдох талуудтай тохиролцоод байна.

Дээрх үйл ажиллагаа зөрчил биш бөгөөд манай зүгээс авсан арга хэмжээнийхээ тухай тайланг ойрын хугацаанд хүргүүлэн хамтран ажиллах хүсэлтэй байна.

ДАРГА

У.БЯМБАСҮРЭН



IDA 2020 onl Alham bichig Bank Ltd
2020000170



**БУЛГАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Анхдагчид 1-125

Утас: 7034-2739, Факс: 7034-3117

http://www.bu_hhaag@yahoo.com

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

2020.04.20 № 1/125
Танай _____-ны № _____ т

Тайлбар хүргүүлэх тухай

Шинэ хөдөө төслийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт хийсэн ахлах аудитор Д.Мөнхтуяагийн албан шаардлагатай танилцаж дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. Герефорд үүлдрийн бух 15, Сэлэнгэ-герефортын 1-р үеийн эрлийз 35 бухыг худалдан авахдаа Монгол улсад сонгон үржүүлж байгаа "Газар-Агро" ХХК гэрээ байгуулан худалдан авалт хийсэн болно. Тус аж ахуйн нэгжтэй нэмэлт гэрээ байгуулж 2020 оны 4 сарын 1 нд авахаар тохирсон боловч арчилгаа маллагааны зардал сумдад байхгүй учир 5 сарын 1 болгож хойшлуулах саналыг гүйцэтгэгчид хүргүүлж зөвшилцөлд хүрсэн. Гэвч шалгалтын явцад 4 сарын 1 нд бухнуудыг авч сумдад хүргүүлэх чиглэл өсгөн тул 100 хувь хүлээн авч сумдад хүргүүлээд байна.
2. Сэлэнгэ үүлдрийн бух 44 авах ажлыг энэ үүлдрийн үхрийн автор О.Мэдэхгүй захиралтай "Хөгнө-Мээж" ХХК-тай гэрээ байгуулж авсан бөгөөд мөн өсгөн бойжуулалт хийлгэж авахаар тохирч 4 сарын 13 өдөр 100 хувь хүлээн авч сумдад хүргүүлсэн.
3. Зохиомол хээлтүүлгийн багаж тоног төхөөрөмжийг "Дүүнхэр-Тэргүүн" ХХК-иас худалдан авалт хийж, ХХААГ-ын складад хүлээн аваад байна. Энэ тоног төхөөрөмжийг 3 сард зохион байгуулах зохиомол хээлтүүлэгийн сургалтанд суралцсан хүмүүст олгохоор бэлтгэд ажлыг хангаж байсан боловч коронавирусын улмаас хойшлогдсон тул хүлээгдэж байгаа болно.
4. Төмс, хүнсний ногооны техник, тоног төхөөрөмжийг 100 хувь хүлээн авч сумдад хүлээлгэн өгсөн. Гэрээ байгуулах ажлыг 2 сард хийхээр төлөвлөж, коронавирусын улмаас хойшилж 4 сарын 5-аас эхлэн сумдаар явж гэрээ байгууллаа.
5. Айраг хадгалах хөргүүртэй чингэлэг нийлүүлэх ажлын тендэрт аж ахуйн нэгжүүд ороогүй учир сүүний хөргөлтийн танк нийлүүлэх тендэрт орж гэрээ байгуулсан "Согриглуун" ХХК-нд санал тавьж гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тус компани нийлүүлэх ажил хийсэн боловч манай зүгээс нэмэлт ажил шаардаж хийлгүүлээд 4 сарын 19 нд Сайхан суманд хүлээлгэн өгсөн болно.
6. Сүүний хөргүүртэй танк худалдан авах ажлыг "Согриглуун" ХХК-ни гэрээ байгуулж 100 хувь хүлээн авч сумдад хүргүүлсэн. Энэ сарын 4-өөс эхлэн 19 хооронд бүх сумдад ажиллаж сүүний хөргөлтийн танкийг эзэнжүүлж гэрээ байгууллаа.

Иймд дээрх ажлуудыг 4 сарын 3-аас эхлэн "Шинэ хөдөө-хөгжил" ОНӨААТҮГ-тай хамтарсан ажлын хэсэг сумдад ажиллаж гэрээ байгуулж, эзэнжүүлэх ажил хийгдсэн тул та бүхэн бидний хийсэн ажил, цаг үеийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан үзнэ үү.

ДАРГА

Ч.АМГАЛАН



Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитад өгөх санал

№	Зөвлөмж	Хариуцах хэлтэс
1.1	Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлуудыг төлөвлөж батлахдаа зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан барилга байгууламжийн ажлыг <u>баталж</u> байх	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
1.2	Барилга байгууламжийн ажил эхлэхээс өмнө газарзүйн төлөвлөгөөнд тусгуулан газрын тухай хуулийн дагуу газрын зөвшөөрлийг гаргуулж хянах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
1.5	Төсөл, арга хэмжээний ажлуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ажлын хэсэг болон комиссын гишүүдийн хяналтыг сайжруулах тал дээр арга хэмжээ авч ажиллах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Тайлбар:

1. Салбарын яам, Засгийн газарт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн хүргүүлдэг.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг Улсын Их Хурал хэлэлцэн батлагддаг.

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Батцогт

Б.Очирсүрэн



ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1.
